


БАТЛАВ.
“ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ”
ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ  Т.ТӨМӨРБААТАР

2018 оны 07 дугаар сарын  ний өдөр

БАТЛАВ.
“ЭВ НЭГДЭЛ” ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ
ДАРГА  ЦАРИУНБААТАР

2018 оны 07 дугаар сарын  ний өдөр

2018-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАЙГУУЛСАН ХАМТЫН ГЭРЭЭ

2018 оны 07 дугаар сарын 20 өдөр

Улаанбаатар хот

Хамтын гэрээний талууд:

Нэг талаас: “Зорчигч Тээврийн Нэгтгэл” ОНӨААТҮГ-ын захиргаа /Цаашид ажил олгогч гэх/

Нөгөө талаас: “Зорчигч Тээврийн Нэгтгэл” ОНӨААТҮГ-ын ажилтны “Эв нэгдэл” үйлдвэрчний эвлэлийн хороо /Цаашид ҮЭ хороо гэх /


Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 1-2-р бүлэг, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн зүйл заалтыг хэрэгжүүлэхээр хуулиар зохицуулаагүй эрхийн харилцааг зохицуулах, үйлчилгээний соёл чанарын түвшинг дээшлүүлэх, ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалахад хамтын гэрээний зорилго оршино.

1.2 Энэхүү хамтын гэрээ нь бүртгүүлсэн өдрөөс хойш 2 жилийн хугацаанд мөрдөгдөх бөгөөд дахин шинээр байгуулагдаагүй бол дараагийн гэрээ батлагдах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

1.3 Аж ахуйн нэгжийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөх нь хамтын гэрээг цуцлах үндэслэл болохгүй.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1.4 Аж ахуйн нэгж байгууллагыг өөрчлөн байгуулах, өмчлөгч өөрчлөгдсөн тохиолдолд хамтын гэрээ мөрдөгдөх бөгөөд түүнд нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл хамтын гэрээг шинэчлэн байгуулах асуудлыг ажил олгогч, ажилтны төлөөлөгчид гэрээ хийж шийдвэрлэнэ.

1.5 Хамтын гэрээнд Монгол улсад мөрдөгдөж буй хууль дүрэм зөрчсөн заалт орсон бол хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн заалт баримтлана.

1.6 Хамтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг аль ч тал гаргаж болно. Нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа бичгээр мэдэгдэнэ.

Хоёр. Цалин хөлсний талаар

2.1 Ажил олгогч нь ажилтантай тохиролцож ажил албан тушаал хавсран ба хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны ажил үүргийг орлон гүйцэтгэсэн тохиолдолд үндсэн цалингийн 20 хүртэлх хувиар тооцож олгоно.

2.2 Ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар болон 7 хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол 1.5 дахин, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол дундаж цалингийн хөлсийг 2.0 дахин нэмэгдүүлж олгоно.

2.3 Ажилтнуудын цалин хөлсийг сар бүрийн 10 болон 22-ны өдрөөс тооцоо тасалснаас хойш ажлын 5 хоногт багтааж банкны картаар саадгүй олгоно. Байгууллагаас хамаарахгүй шалтгаанаар ажлын 5 хоног хэтэрсэн тохиолдолд байгууллага хариуцлага хүлээхгүй болно.

2.4 Ажилтаныг удаан жил, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор Автотээврийн салбарт "Удаан жил ажилласны цалингийн нэмэгдэл"-ийг олгож болно. Ингэхдээ байгууллагын цалин хөлсний журмаар зохицуулна.

2.5 Байгууллагын жилийн эцсийн ажлын үр дүнг харгалзан тухайн жилийн ашигаас тодорхой хувиар ажилтнуудад ажлын байрны онцлог, байгууллагын үйл ажиллагаанд оруулсан хувь нэмрийг нь харгалзан жилийн эцсийн үр дүнгийн болон сар бүрийн урамшуулалт шагналт цалинг байгууллагын цалин хөлсний журмаар олгож болно.

БҮРТГЭЭ № 02
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ-ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2.6 Ажил олгогч нь ажилтнуудын цалин хөлсийг Засгийн газраас цалин хөлсийг нэмэгдүүлэх шийдвэр гарсантай уялдуулан тухай бүр нэмэгдүүлнэ. /ҮЭ-ийн хороотой зөвшилцөнө/

2.7. Тухайн байгууллагад 5-аас дээш жил үр бүтээлтэй ажилласан ажилтны гаргасан хүсэлтийн дагуу 2 хүртэлх сарын үндсэн цалин жилд нэг удаа улиралдаа багтаан буцаан төлөх нөхцөлтэйгөөр урьдчилан олгож болно.

2.8 Цалин хөлсийг зөв бодох, хууль бус суутгал хийхгүй байх. Хэрвээ цалин буруу бодсон, хууль бус суутгал хийсэн зөрчил илэрсэн тохиолдолд буруутай этгээдэд хариуцлага тооцно.

Гурав. Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны баталгааны талаар

3.1 Байгууллагын үр дүнгийн тайлан хэлэлцэх, ажил мэргэжлийн зөвлөгөө хийх, хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, цалин хөлсний журам, норм норматив тогтоох зэрэг асуудлыг хэлэлцэхэд ҮЭ-ийн дарга, төлөөллийг оролцуулан санал авч болно.


3.2 Шатахууны норм, нормативийг тогтоохдоо төрийн захиргааны төв байгууллага болох харьяа яамны сайдын баталсан тушаал журмыг баримтлан ажиллана. Түлш шатахууны зарцуулалт төлөлтийг байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа шатахууны журмыг баримтлан хэн буруутай этгээдээр төлүүлэн хариуцлага тооцно.

3.3 Сайн дурын даатгалыг ажилчдын төлөөлөл ҮЭ-ийн санал хүсэлтийг авч, зөвшилцөж даатгалын компанитай гэрээ байгуулна.

3.4. “Зорчигч Тээврийн Нэгтгэл” ОНӨААТҮГ-ын бааз байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарч байгаа ажилтанд ажлаас гарахад тухайн байгууллагад тасралтгүй ажилласан жилээс нь хамааруулан дундаж цалинтай тэнцэх тэтгэмжийг доорх хэмжээгээр 1 удаа олгоно.

1-5 жил хүртэл ажилласан бол 1 сар

6-10 жил хүртэл ажилласан бол 4 сар



11-15 жил хүртэл ажилласан бол 8 сар

16-20 жил хүртэл ажилласан бол 10 сар

21-25 жил хүртэл ажилласан бол 12 сар

26 –аас дээш жил ажилласан бол 15 сар

Тасралтгүй ажилласан жилийг байгууллагад ажилд орсон хамгийн сүүлийн тушаалаар тооцох бөгөөд дундаж цалин хөлсийг тооцохдоо НХХЯ-ны сайдын баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын дагуу бүх төрлийн хөнгөлөлтийг хасаж тооцно.

3.5 Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажилд шилжүүлээгүй бол сул зогсолтын олговрыг үндсэн цалингийн 60 хувиар тооцон олгоно.

Дөрөв: Ажил амралтын цагийн талаар

4.1 Ажил олгогч нь ажилтанд доорхи тохиолдолд цалингүй чөлөө олгоно.

4.1.1 Ажилтан хурим хийвэл \ажлын 3 хоног\

4.1.2 Ажилтаны эхнэр амаржсан тохиолдолд \ажлын 5 хоног\

4.1.3 Төрсөн хүүхэд нь хурим хийвэл \ажлын 3 хоног\

4.1.4 Эцэг, эх гэр бүлийн хүмүүс нь нас барсан тохиолдолд \ажлын 5 хоног\


4.2 Ажлын ачаалал, үйлчилгээний орлоготой уялдуулан ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг оны эхэнд гарган, батлагдсан хуваарийн дагуу амралтыг биеэр эдлүүлнэ. Групп, хүүхэд асрах чөлөөний хугацаа дууссан болон дуусаагүй ажилд орсон ажилтан 6 сар бүтэн ажилласны дараа ээлжийн амралт авах эрхтэй.

4.3 Зорчигч үйлчилгээний автобус, троллейбусны жолооч, шалгагч нарын өдөрт тасралтгүй ажиллах хугацаа 8 цагаас илүүгүй байна.

Тав. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар

5.1 Ажил олгогч нь ХАБЭА-н тухай хуулийг мөрдөн ажиллаж ХАБЭА-н нөхцлийг сайжруулахад санхүүжилтыг ХАБЭА-н тухай хуулийн 26.2 дахь заагыг баримтлан ажиллана.

ХАН УУЛ ДҮҮРГИЙГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗАР



5.2 Хортой нөхцөлд ажилладаг ажилтнуудад хор саармагжуулах ундааг ажилласан өдөр тутамд нь олгож хэвшүүлнэ.

5.3 Ажил олгогч нь автобус, троллейбусны жолооч, шалгагч, засвар техникийн ажилтан, албан хаагчдыг ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг үнэ төлбөргүйгээр хангана.

5.4 Мэргэжлийн байгууллагатай хамтран галын аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал, ажлын байр, эрүүл ахуйн үзлэгийг жилд 1 удаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах ажлыг зохион байгуулна.

5.5 Хөдөлмөрийн хэвийн болон хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилтнуудыг жилд 1 удаа эмнэлгийн үзлэгт хөнгөлөлттэй нөхцлөөр хамруулна.

5.6 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг дагаж мөрдөх мэргэжлийн баг ажиллана.

Зургаа. Ажилтны мэргэжил, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар

6.1. Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хууль эрх зүй, эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын сургалтын хөтөлбөрийг боловсруулан сургалтыг байнга зохион байгуулна.

6.2 Инженер, техникийн болон засвар үйлчилгээний ажилтнуудыг мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулна.

6.3 Үйлдвэрийн газрын захиалгаар ажилтнуудын мэргэжлийг дээшлүүлэх, гадаад дотоодын сургалт, семинарт суралцах хугацаанд цалинтай чөлөө олгоно.

Долоо. Нийгэм ахуйн хөнгөлөлтийн талаар

7.1 Улсын чанартай амралт сувилалд хувийн зардлаар явж амарч сувилуулсан ажилтанд холбогдох эрхийн бичгийн төлбөрийн баримтыг үндэслэн жилд 1 удаа 5 хувийн нөхөн олговрыг захиргаа, 10 хувийн нөхөн олговрыг Үйлдвэрчний эвлэлээс олгоно.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАСАР

7.2 Ажилтануудыг саунд 3000 төгрөг, халуун усанд 1000 төгрөгөөр үйлчилнэ.

7.3 Тус үйлдвэрийн газарт 5 жилээс дээш үр бүтээлтэй ажиллаж байгаа болон тэргүүний ажилтнуудад орон сууц худалдан авахад нь санхүүгийн туслалцааг захирлын зөвлөлийн шийдвэрээр байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

7.4 Ажилтнуудад ажлын нэг өдөрт хоолны хөнгөлөлтөнд 3000, унааны хөнгөлөлтөнд 1000 төгрөгийг ажил олгогч олгоно.

7.5 Ганц бие өрх толгойлсон, амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой ажилтнуудын гэр бүлийн судалгаа гаргаж жилд 10 хүртэлх хүүхдийн сургалтын төлбөрт зохих хөнгөлөлтийг захирлын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

7.6 Ажилтан нь ажлын байранд нас барсан тохиолдолд ар гэрт нь 1 удаагийн буцалтгүй тусламж 1 000 000 /нэг сая/ төгрөгийг байгууллагын дотоод журамд заасны дагуу олгоно.

7.7 Захиргааны зүгээс ажилтанд олгох бусад тусламжийг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу олгоно.

7.8 Ажилчдын сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

7.9. Ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байгаа үедээ эрүүл мэндийн хохирол үзэж гадаад, дотоодод эмчлүүлэх шаардлагатай болсон үед эмчилгээний зардалд үзүүлэх туслалцааг захирлын зөвлөлийн хурлаар шийдвэрлэж болно.

Найм. Хөдөлмөрлөх эрхийн харилцаатай холбоотой бусад асуудлын талаар

8.1 Тээврийн хэрэгсэл /троллейбус, автобус/-ийн парк шинэчлэх, өндөр настан, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутан сурагчдын нөхөн олговрыг цаг хугацаанд нь авах, НДШ-ийн өрийн асуудал үнэ тарифын алдагдлыг бүрэн авах талаар ҮЭХ, захиргаа хамтран холбогдох эрх бүхий байгууллагуудад асуудал тавьж шийдвэрлүүлнэ.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ОНОЛГО
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАСАР

8.2 Захиргаа “Өндөр бүтээлийн уралдаант аян”-ыг байгууллагын ажилтнуудын дунд зарлан дүгнэж, шалгарсан тэргүүний ажилтнуудыг шагнал урамшилд хамруулах аялал, зугаалганд оролцуулна. ҮЭ-тэй хамтран хийнэ.

Ес. ҮЭ-ийн болон төрийн бус байгууллагын эрхийг хангах талаар

9.1 Захиргаа нь ҮЭ-ийн байгууллагыг ажиллах нөхцөл бололцоогоор /хурал, уулзалт хийх байр, албан конторын өрөө, ширээ сандал, шаардлагатай мэдээлэл судалгаагаар/ хангана.

9.2 МҮЭ-ийн холбоо, Салбарын ҮЭ-ийн холбоо, ҮЭ-ийн хороо, Олон улсын байгууллагаас зохион байгуулж буй сургалт семинар, хурал зөвөлгөөн, компанит ажлуудад ҮЭ-ийн гишүүдийг оролцуулахад захиргаанаас цалингүй чөлөө олгож холбогдох зардлыг ҮЭ-ээс дэмжлэг үзүүлнэ.

9.3 Байгууллагын ажил үүрэгтэй холбоотой нууцын зэрэглэлд хамааралгүй бичиг материал, мэдээ мэдээллийг тухайн баазын ҮЭ-ийн хороон даргад ажил олгогч нь ажлын 5 өдөрт багтааж гаргаж өгнө. Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээ, мэдээлэл, материалыг харилцан солилцох ба мэдээллийн нууцыг хадгална.

9.4 ҮЭ-ийн хорооны даргын үндсэн цалинг 860000 төгрөгөөр цалинжуулах бөгөөд ажлын үр дүн, үзүүлэлтийг харгалзан 40 хувийн нэмэгдэл олгож болно.

9.5 ҮЭ-ийн хорооны гишүүдийн татварыг сар бүр бэлэн бусаар хурааж, үйлдвэрчний эвлэлийн хорооны дансанд шилжүүлэх үүргийг байгууллагын захиргаа хүлээнэ.

9.6 ҮЭ-ийн хорооны гишүүдийн хөдөлмөрлөх эрх түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхолыг хөндөх аливаа шийдвэр гаргахдаа ҮЭ хороонд танилцуулж саналыг тусгаж байна.

Арав. Үйлдвэрчний эвлэлийн хорооны хүлээх үүрэг

10.1 Ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилт, ажлын байрны баталгаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад

нийцсэн хөдөлмөрийн аятай нөхцлийг хангуулах талаар яриа хэлэлцээ хийх, тэдгээрийг сахин биелүүлэхийг ажилтан болон захиргаанаас шаардаж улмаар "Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай" хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

10.2 ҮЭ-ийн гишүүд, ажилтнууд нь ҮЭ-ийн хорооноос шийдвэр гаргахад нээлттэй оролцох боломжоор хангах, ҮЭ-ийн санхүүгийн тайланг бүх гишүүддээ ил тод тайлагнах, өмч хөрөнгө санхүүгийн сахилгыг чанд мөрдөх, ҮЭ-ийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, өмч хөрөнгө, санхүүгийн хувьд бие даасан бодлого явуулж хэрэгжүүлнэ.

10.3 Ажилтнуудын эрэлт хэрэгцээг судлан тэдний хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах, ажлын байрны эрсдлийг бууруулах, үйлдвэрлэлийн ослыг тэглэх, ёс зүй, харьцаа хандлагыг өндөржүүлэх зэрэгт чиглэгдсэн бүх төрлийн сургалт, уулзалтыг зохион явуулж, сургалт сурталчилгааны арга хэмжээнд зарцуулсан тухай тайлангаа улирал бүр гишүүдэд тайлагнана.

10.4 Ажилтнуудыг идэвхжүүлэх, ур чадварыг нь нэмэгдүүлэх, байгууллагын тогтсон соёлыг байнга сайжруулах, ажлын зөв соёл, бүтээмжтэй ажиллахад нөлөөлөх зорилгоор спортын тэмцээн уралдаан, тойрон аялал зэргийг зохион байгуулна.

10.5 Байгууллагын үйл ажиллагаанд ажилтнуудыг идэвхтэй оролцуулах, ажлын байранд эмх цэгц, ёс зүй, дэг журмыг хэвшүүлэх, тохилго бүтээмжтэй ажлын орчинг бий болгох, чанар бүтээмжийг сайжруулах зорилгоор ажилтнууд болон удирдлагын хамтын ярилцлага, хэлэлцүүлэг зэрэг ажил явуулж, тэдний хамтын ажиллагааг дэмжиж хамтарч ажиллана.

10.6 Үйлдвэрчний эвлэлийн хорооноос хамт олны дунд спортын өдөрлөг, аялал, ажил мэргэжлийн уралдааныг явуулахдаа байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйн тулд холбогдох албан тушаалтнуудтай урьдчилан зөвшилцсөн байна.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ТАЧАРВ

Арван нэг. Хамтын гэрээний биелэлтэнд хяналт тавьж дүгнэх талаар

11.1 Хамтын гэрээний биелэлтэд талууд болон тэдгээрийн төлөөлөгчид хяналт тавьж, энэхүү гэрээний биелэлтийг хагас жилд дүгнэн нийт ажилтнуудад мэдээлнэ.

11.2 Ажил олгогч нь хамтын гэрээнд заасан үүргүүдийг байгууллагын жилийн, хагас жилийн, улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулж хэрэгжүүлнэ.

11.3 Хамтын гэрээ байгуулах явцад болон хэрэгжилтэнд хяналт тавиагүй, гэрээний үүргийг санаатайгаар биелүүлээгүй албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

1. Г.Төмөрбаатар
2. Б.Даваасүрэн
3. С.Түмэн-Ундармаа
4. М.Цэнд
5. Б.Дуламсүрэн
6. Д.Отгонсүрэн
7. Ц.Баясгалан
8. Б.Бат-Орших
9. Н.Баярбат
10. Ч.Баярсүрэн
11. М.Өнөрбаяр
12. Ч.Батбаатар
13. О.Санжаасүрэн
14. Д.Мөнхзул
15. Д.Баатархүү
16. Л.Тулга
17. Х.Ариунжаргал
18. А.Амарсайхан

ҮЭХ-Г ТӨЛӨӨЛЖ:

1. Ц.Ариунбаатар
2. О.Баасанжав
3. Ж.Энхбаяр
4. Д.Байгалмаа
5. Д.Мөнхбаяр
6. С.Мөнхсүлд
7. Г.Дашдондов
8. М.Чинзориг
9. У.Сайханцэцэг
10. М.Ганчимэг
11. Б.Эрдэнэлхагва
12. С.Энхбат
13. Б.Хишигбат
14. П.Ганбаатар
15. Ц.Өлзийтогтох
16. М.Батжаргал
17. Т.Бүрэнжаргал
18. Г.Баярмаа

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР